



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох
Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13-14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТҮРГЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2026.02.24 № УВА-2026/112/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түргэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 3,452.8 мянган төгрөгийг бэлэг дурсгал, хоол, унаа, байрны зардалд, 653.5 мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа авсан, 500.0 мянган төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгуулсан, А/52 дугаар захирамжаар Махардгийн овоо тахихад 3,200.0 мянга, А/24 дүгээр тушаалаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчид ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5,000.0 мянга, нийт 11,652.8 төгрөгийг төсвөөс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4

8525050590

дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>83,760,346.00</u>	<u>119,825,414.00</u>
33	АВЛАГА	846,530.00	846,530.00
335	Бусад авлага	846,530.00	846,530.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	846,530.00	846,530.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,913,816.00	118,978,884.00
354	Хангамжийн материал	59,130,308.00	94,845,376.00
35410	Бичиг хэргийн материал	2,223,690.00	2,733,690.00
35420	Аж ахуйн материал	47,611,618.00	82,466,686.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,110,000.00	7,460,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,185,000.00	2,185,000.00
35500	Биологийн хөрөнгө	-	350,000.00
35600	Мал амьтад	23,783,508.00	23,783,508.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,737,368,798.37</u>	<u>2,462,878,655.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,737,368,798.37	2,462,878,655.26
392	Биет хөрөнгө	1,260,074,798.37	1,951,184,655.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,523,900,239.61	1,448,797,840.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(593,672,459.13)	(524,119,852.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	324,827,073.00	389,847,273.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(179,994,257.07)	(152,150,896.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	279,835,551.42	296,321,865.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(193,180,070.38)	(180,248,501.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,600,296.97	87,655,890.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,211,848.53)	(21,751,063.68)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	99,415,374.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	167,397,182.00	283,948,182.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(92,426,909.52)	(98,482,206.96)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	321,950,751.00
393	Биет бус хөрөнгө	477,294,000.00	511,694,000.00
39301	Програм хангамж	2,605,000.00	5,605,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,605,000.00)	(2,605,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	477,294,000.00	508,694,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,821,129,144.37</u>	<u>2,582,704,069.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8,051,614.26</u>	<u>109,673,518.67</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,051,614.26	109,673,518.67
413	Өглөг	8,051,614.26	109,673,518.67

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,915,114.26	519,317.67
4136	Бусад өглөг	136,500.00	109,154,201.00
41361	Байгууллагад төлөх өглөг	136,500.00	108,287,601.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	866,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,813,077,530.11</u>	<u>2,473,030,550.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,813,077,530.11	2,473,030,550.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	808,396,535.49	808,396,535.49
512	Хуримтлагдсан үр дүн	675,839,594.62	1,390,303,670.10
51210	Өмнөх үеийн үр дүн	675,839,594.62	730,350,649.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	659,953,020.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328,841,400.00	274,330,345.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,821,129,144.37</u>	<u>2,582,704,069.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,096,184,296.00	1,803,463,559.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,346,530.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,346,530.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,346,530.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,346,530.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	91,404,273.00	488,563,835.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	9,675,000.00	56,368,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	993,758,493.00	1,258,531,724.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,562,293.00	315,399,824.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,045,100.00	313,897,324.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,517,193.00	1,502,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	948,196,200.00	943,131,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	948,196,200.00	943,131,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,014,688,695.26	1,141,452,839.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,688,695.26	1,141,452,839.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901,039,063.25	975,656,676.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,143,201.92	668,758,900.49
210101	Үндсэн цалин	363,899,811.17	405,136,761.39
210102	Нэмэгдэл	202,705,607.70	248,842,505.60
210104	Урамшуулал	9,693,220.50	11,539,633.50
210105	Гэрээт ажлын хөлс	13,844,562.55	3,240,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шинтгэл	73,522,463.08	81,897,283.70
210201	Тэтгэврийн даатгал	50,929,699.12	56,929,756.88

210202	Тэтгэмжийн даатгал	5,834,818.15	6,690,657.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,917,398.21	3,606,343.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,917,396.87	2,934,105.24
210205	Эрүүл мэндийн даатгал	10,923,150.73	11,736,421.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,857,247.90	41,780,776.00
210301	Гэрэл, цахилгаан	1,895,357.92	5,621,416.32
210302	Түлш, халаалт	34,961,889.98	36,159,359.68
2104	Хангамж, бараа материалын зардал	81,686,673.35	63,073,337.00
210401	Бичиг хэрэг	3,349,300.00	4,212,950.00
210402	Тээвэр, шатахуун	51,775,880.00	28,799,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,341,861.35	1,737,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,369,700.00	8,128,300.00
210408	Бараа материал акталсны зардал	22,849,932.00	20,194,932.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	-
210502	Хоол, хүнс	1,800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,130,900.00	6,354,200.00
210604	Урсгал засвар	9,130,900.00	6,354,200.00
2107	Томилолт, зочны зардал	12,768,000.00	4,458,500.00
210702	Дотоод албан томилолт	12,768,000.00	4,458,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,271,646.00	6,463,749.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,440,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,736.00	532,389.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,015,000.00	-
210807	Газрын төлбөр	440,460.00	491,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,858,931.00	102,869,930.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,858,931.00	31,562,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,060,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	66,247,030.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,649,632.01	165,796,163.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,720,777.00	49,525,364.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,402,800.00	48,665,364.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,457,977.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	860,000.00	860,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,928,855.01	116,270,799.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,928,855.01	116,270,799.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	81,495,600.74	662,010,720.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	81,495,600.74	662,010,720.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	994,258,493.00	1,258,531,724.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	993,758,493.00	1,258,531,724.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,562,293.00	315,399,824.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,045,100.00	313,897,324.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,517,193.00	1,502,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	948,196,200.00	943,131,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	948,196,200.00	943,131,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	917,327,849.00	1,058,531,724.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	917,327,849.00	1,058,531,724.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,991,016.99	892,735,560.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,747,405.42	675,911,365.63
210101	Үндсэн цалин	356,407,364.67	426,836,336.30
210102	Нэмэгдэл	204,362,327.70	232,353,426.26
210104	Урамшуулал	9,693,220.50	11,728,481.77
210105	Гэрээт ажлын хөлс	12,284,492.55	4,993,121.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,003,145.32	82,140,615.15
210201	Тэтгэврийн даатгал	49,663,733.87	56,170,802.36
210202	Тэтгэмжийн даатгал	5,834,818.15	6,507,684.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,917,398.21	3,273,609.79
210204	Ажилгүйдлийн даатгал	2,917,396.87	3,245,386.10
210205	Эрүүл мэндийн даатгал	11,669,798.22	12,943,132.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,857,247.90	41,780,776.00
210301	Гэрэл, сахилгаан	1,895,357.92	5,621,416.32
210302	Түлш, халаалт	34,961,889.98	36,159,359.68
2104	Хангамж, бараа материалын зардал	29,441,841.35	22,786,755.00
210401	Бичиг хэрэг	2,733,300.00	1,754,450.00
210402	Тээвэр, шатахуун	23,148,980.00	18,358,405.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,341,861.35	1,746,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,217,700.00	927,000.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,699,500.00	10,879,400.00
210604	Урсгал засвар	8,699,500.00	10,879,400.00
2107	Томилолт, зочны зардал	12,768,000.00	3,740,000.00
210702	Дотоод албан томилолт	12,768,000.00	3,740,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,351,646.00	8,548,749.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,525,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,736.00	543,989.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,095,000.00	3,000,000.00
210807	Газрын төлбөр	440,460.00	479,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,622,231.00	46,947,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,622,231.00	41,887,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	5,060,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,336,832.01	165,796,163.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,407,977.00	49,525,364.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,665,364.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,457,977.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	860,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,928,855.01	116,270,799.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,928,855.01	116,270,799.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	76,930,644.00	200,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,508,650.00	200,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,508,650.00	200,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,508,650.00	200,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	200,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,508,650.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,508,650.00)	(200,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	66,421,994.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	808,396,535.49	328,841,400.00	675,839,594.62		1,813,077,530.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	808,396,535.49	328,841,400.00	675,839,594.62	-	1,813,077,530.11
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	808,396,535.49	328,841,400.00	675,839,594.62	-
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	808,396,535.49	328,841,400.00	675,839,594.62	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	54,511,055.00	54,511,055.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	808,396,535.49	328,841,400.00	730,350,649.62	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(54,511,055.00)	-	(54,511,055.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	659,953,020.48	659,953,020.48
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	808,396,535.49	274,330,345.00	1,390,303,670.10	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	938,166,800.00	929,374,351.87	8,792,448.13	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,166,800.00	929,374,351.87	8,792,448.13	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	887,999,500.00	879,848,987.87	8,150,512.13	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,154,200.00	675,396,865.63	757,334.37	99.9
210101	Үндсэн цалин	642,194,800.00	426,836,336.30	215,358,463.70	66.5
210102	Нэмэгдэл	-	232,353,426.26	(232,353,426.26)	0.0
210104	Урамшуулал	9,286,200.00	11,213,981.77	(1,927,781.77)	120.8
210105	Гэрээт ажлын хөлс	24,673,200.00	4,993,121.30	19,680,078.70	20.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,359,800.00	82,081,447.15	1,278,352.85	98.5
210201	Тэтгэврийн даатгал	56,683,900.00	56,111,634.36	572,265.64	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,669,800.00	6,507,684.58	162,115.42	97.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,334,500.00	3,273,609.79	60,890.21	98.2

210204	Ажилгүйдлийн даатгал	3,334,500.00	3,245,386.10	89,113.90	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,337,100.00	12,943,132.32	393,967.68	97.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,857,200.00	41,780,776.00	4,076,424.00	91.1
210301	Гэрэл, цахилгаан	10,263,000.00	5,621,416.32	4,641,583.68	54.8
210302	Түлш, халаалт	35,594,200.00	36,159,359.68	(565,159.68)	101.6
2104	Хангамж, бараа материалын зардал	28,481,300.00	19,998,850.00	8,482,450.00	70.2
210401	Бичиг хэрэг	1,385,800.00	1,254,450.00	131,350.00	90.5
210402	Тээвэр, шатахуун	23,373,000.00	16,985,500.00	6,387,500.00	72.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,308,500.00	1,746,900.00	561,600.00	75.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	-	250,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,164,000.00	12,000.00	1,152,000.00	1.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,891,500.00	10,879,400.00	6,012,100.00	64.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,300,000.00	-	2,300,000.00	0.0
210604	Урсгал засвар	14,591,500.00	10,879,400.00	3,712,100.00	74.6
2107	Томилолт, зочны зардал	4,458,700.00	3,740,000.00	718,700.00	83.9
210702	Дотоод албан томилолт	4,458,700.00	3,740,000.00	718,700.00	83.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,692,300.00	4,023,749.09	3,668,550.91	52.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	-	450,000.00	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-	288,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	831,000.00	-	831,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,099,900.00	543,989.09	555,910.91	49.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	-	220,000.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,843,500.00	3,000,000.00	843,500.00	78.1
210807	Газрын төлбөр	959,900.00	479,760.00	480,140.00	50.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,104,500.00	41,947,900.00	(16,843,400.00)	167.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,590,100.00	41,887,900.00	(17,297,800.00)	170.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	514,400.00	60,000.00	454,400.00	11.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,167,300.00	49,525,364.00	641,936.00	98.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,167,300.00	49,525,364.00	641,936.00	98.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,667,300.00	48,665,364.00	1,936.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	860,000.00	640,000.00	57.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	929,374,351.87	(929,374,351.87)	0.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	929,374,351.87	(929,374,351.87)	0.0
132001	Орон нутгийн төсвөөс	-	929,374,351.87	(929,374,351.87)	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	212,886,573.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,886,573.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	12,886,573.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	514,500.00
210104	Урамшуулал	-	514,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	59,168.00
210201	Тэтгэврийн даатгал	-	59,168.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,787,905.00
210401	Бичиг хэрэг	-	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,372,905.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	915,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,525,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,525,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	200,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	200,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	200,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	315,399,824.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	315,399,824.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	313,897,324.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,502,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанартай, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлсөн байна.

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн " CTSystem " программ хангамж ашигладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 725,575.0 мянган төгрөгөөр буюу 41.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	846.5	846.5	0.0
Бараа материал	82,913.8	118,978.9	36,065.1
Үндсэн хөрөнгө	1,737,368.8	2,462,878.7	725,509.9
Нийт хөрөнгө	1,821,129.1	2,582,704.1	761,575.0
Өр төлбөр	8,051.6	109,673.5	101,621.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,813,077.5	2,473,030.6	659,953.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,821,129.1	2,582,704.1	761,575.0

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 846.5 мянган төгрөгийн үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118,978.9 мянган төгрөг болж 36,065.1 мянган төгрөг болж өссөн нь аж ахуйн материал, түлш шатах тослох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,462,878.7 мянган төгрөг болж 725,509.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 305,250.7 мянга, бусад үндсэн хөрөнгө болон үнэ төлбөргүй хүлээн авсан 488,563.8 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 114,645.0 мянган төгрөг болж 101,621.9 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсөв хуваарийн дагуу олгогдоогүйн улмаас хувь хүний орлогын албан татварын өглөг 519.3 мянга, наадмын талбайн үлдэгдэл санхүүжилт оны эцэст 99,950.7 мянган төгрөг орж ирж шилжүүлэг хийгдээгүй байтал гүйлгээ хаагдсанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,473,030.6 мянган төгрөг болж 659,953.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,131,603.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 188,471.9 мянган төгрөгөөр бууруулж, 943,131.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 943,131.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 943,131.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанд 929,374.4 мянган төгрөгийг зарцуулж 13,757.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 929,374.4 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Үндсэн үйл ажиллагааны зардал : 70106/80101	593,436.0	588,175.2	5,260.8	99.8
2	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Баг хорооны ҮА зардал : 70106/80106	131,882.9	130,072.2	1,810.7	99.4
3	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал : 70106/80111	51,581.7	51,581.7	0	96.1
4	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- нийтлэг үйлчилгээний зардал : 70106/80112	73,847.8	73,847.8	0	99.9
5	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- мэдээлэл сурталчилгааны зардал : 70106/80205	315.0	315.0	0	99.9
6	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- ажил олгогчоос олгох тэтгэмж зардал : 70106/80802	50,167.3	49,527.4	693.9	99.9
7	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- орон нутгийн нөөц хөрөнгийн зардал : 70106/81102	30,000.0	27,530.0	2,470.0	100.0
8	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Мал тооллогын зардал : 70106/81507	750.0	0	750.0	99.9
9	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Хур.Хог хаягдал,орчны бохирдлын зардал : 70106/82212	250.0	0	250.0	100.0
10	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Улсын их баяр наадмын зардал : 70106/82801	5,000.0	2,347.9	2,652.1	100.0
11	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардал : 70106/81701	13,762.6	11,410.0	2,352.6	100.0
12	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага- Ахмад настны хөгжил хамгаалал зардал : 70106/81549	600.0	600.0	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 313,897.3 мянга, Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,502.5 мянга, нийт 315,399.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс: хөрөнгийн зардалд 200,000.0 мянга, 573.7 мянган төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 2,787.9 мянган төгрөгийг хангамж бараа

материалын зардалд, 4,525.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 5,000.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд тус тус зарцуулж, 102,513.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Түргэн сумын Засаг даргын тамгын газар тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь бичиг хэргийн материал 1,754.4 мянга, тээвэр, шатахууны зардалд 18,358.4 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлд 927.0 мянга, урсгал засварын материал 10,879.4 мянга, нийт 31,919.2 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,018,707.9 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 10,187.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,149.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,141,452.8 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 11,414.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,131.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Түргэн сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 165, хугацаа хоцроосон 6 оруулсан мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төсвөөс “Арвиншүтээн” ХХК-д 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн бэлнээр гарган авч хүчин төгөлдөр бус баримтаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа илэрч асуудлыг бүртгэлээр холбогдох албан тушаалтанд танилцуулж ажилласан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/52 тоот албан бичгээр биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,233.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 2,300.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,652.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 1,153.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,127.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс авсан 2,300.0 мянган төгрөгийн цахилгааны нөөц үүсгэврийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2 дахь заалт "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" болон Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

5.1 Төлбөрийн акт

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төсвөөс "Арвиншүтээн" ХХК-д 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн бэлнээр гаргуулан авч зарцуулахдаа 500.0 мянган төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгуулсан, 653.5 мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7 дахь заалтад "Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан архи, согтуурах ундааны 653.5 мянга, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт суутгасан 500.0 мянга, нийт 1,153.5 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар Түргэн сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 3,452.8 мянган төгрөгийг бэлэг дурсгал, хоол, унаа, байрны зардалд, А/52 дугаар захирамжаар Махардгийн овоо тахихад 3,200.0 мянга, А/24 дүгээр тушаалаар Засаг даргын

тамгын газрын албан хаагчид Түргэн сумаас ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5,000.0 мянга, нийт 11,652.8 төгрөгийг төсвөөс зарцуулсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн арга хэмжээ, уулзалт, бэлэг дурсгалын зүйлд 3,452.8 мянга, Махардгийн овоо тахихад 3,200.0 мянга, Засаг даргын тамгын газрын албан хаагчид Түргэн сумаас ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5,000.0 мянга, нийт 11,652.8 төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

- 1.1. Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар хурлын төлөөлөгч нарт дэвтэр бал, хавтасны зардалд 1,127.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- 1.2. Цаашид үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай хамааралгүй зардал гаргахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө дутуу илэрхийлсэн	1	2,300.0					1	2,300.0				
Дүн	1	2,300.0					1	2,300.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Архи согтууруулах ундаа авсан	1	1,153.5	1	1,153.5								
Ойн бэлэг дурсгал, овоо тахилга тээврийн хөлс олгосон	1	11,652.8			1	11,652.8						
Хурлын төлөөлөгч нар дэвтэр, бал, хавтас олгосон	1	1,127.0					1	1,127.0				
Дүн	3	13,933.3	1	1,153.5	1	11,652.8	1	1,127.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР



 /М.БАТСУУРЬ/
 /М.БАТ-АМГАЛАН/
 /Ч.МӨНХТОГТОХ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/11/А2070415
ЗУЛА-2025/112/НА-СТА-ТШЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 3,452.8 мянган төгрөгийг бэлэг дурсгал, хоол, унаа, байрны зардалд, А/52 дугаар захирамжаар Махардгийн овоо тахихад 3,200.0 мянга, А/24 дүгээр тушаалаар Засаг даргын тамгын газрын албан хаагчид Түргэн сумаас ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5,000.0 мянга, нийт 11,652.8 төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 4.2.6 дахь заалтад “Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”, гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь хэсгийг мөрдөн ажиллаж биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түргэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг, нягтлан бодогч О.Элбэгзаяа нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.МӨНХТОГТОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/08/А2070415
УВА-2026/112/НА-СТА-ТШЗ

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түргэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төсвөөс “Арвиншүтээн” ХХК-д 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн бэлнээр гаргуулан авч зарцуулахдаа 500.0 мянган төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгуулсан, 653.5 мянган төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7 дахь заалтад “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт

тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсвөөс архи, согтууруулах ундаа худалдан авахад зарцуулсан 653 500 /зургаан зуун тавин гурван мянга таван зуу/ төгрөг, төсвөөс үргүй зарцуулсан 500 000 /таван зуун мянга/ төгрөг, нийт 1 153 500 /нэг сая нэг зуун тавин гурван мянга таван зуу/ төгрөгийг Засаг дарга Б.Гомбосүрэн, Засаг даргын тамгын газрын даргаар ажиллаж байсан Э.Бямбаа, нягтлан бодогч О.Элбэгзаяа нараар төлүүлж Мэргэжлийн хяналтын газрын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар¹т Түргэн сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэг, нягтлан бодогч О.Элбэгзаяа нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.МӨНХТОРГОХ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ



ААБ 5.5: АУДИТАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУЛДЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Түрэн сумын Засаг даргын тамгын газар
 Аудитын нэр:
 Аудитын код:

№	Ажил гүйцээний анги, дэвчнэ үндэслэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /Мянган төгрөг/	4	5	6	7	8	Шалтгадлыг байгууллагын холбогдох хүний	
									Албан-тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10	
1	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт	Түрэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс Түрэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар Түрэн сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төсөөс 653.5 мянган төгрөгөөр арих согтууруулах ундаа авсан, 500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна.	1,153.0	Төлбөрийн акт				Төлбөрийн акт	Түрэн сумын Засаг даргын тамгын газрын даргаар ажиллаж байсан, нэгтгэн болгох	Э.Бямбаа, О.Элбэгзаяа

Бэлтгэсэн:
 Ахлах аудитор
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Ч.Мөнхтогтох
 2/12/2026

М.Бат-Амгалан
 2/12/2026

Анхан шатанд хянасан:
 Аудитын менежер
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг
 Хоёр дахь шатанд хянасан:
 Дарга, тэргүүлэх аудитор
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг

М.Батсуурь
 2/12/2026

Танилцаж зөвшөөрсөн:
 ЗДТГ-ын Нэгтгэн болгогч
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг

О.Элбэгзаяа
 2/11/2026

Түрэн сумын Засаг дарга
 Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Э.Бямбаа
 2/12/2026

О.Элбэгзаяа
 2/11/2026

Э.Бямбаа
 2/12/2026